



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/129

Зуунмод

Хичээл сургалтын үйл ажиллагааг
хэсэгчлэн эхлүүлэхтэй холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.12, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Монгол Улсын Онцгой Комиссын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаал, Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/58 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой ковид-19 цар тахлын халдварын тархалт, түүнээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын эрсдэлийн үнэлгээ”-ний дүнг үндэслэн, өндөржүүлсэн бэлэн байдлын үед Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн танхимын хичээл сургалтын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлсүгэй.

2. Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/58 дугаар тушаалаар батлагдсан “Түр журам”-ыг чанд хэрэгжүүлэн, хичээл сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэх, бэлэн байдал хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч нарт, хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, чиглэл хүргүүлэн ажиллахыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар (Р.Ундрахбаяр)-т тус тус даалгасугай.

3. Улаанбаатар хотоос орон нутаг руу зорчих хөдөлгөөн 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс нээгдэж голомттой бүс нутгаас ирж байгаа иргэд эрс нэмэгдсэн, цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулахтай холбоотойгоор бүх шатны боловсролын байгууллагад эрсэдлийн үнэлгээг хийж 2021 оны 03 дугаар сарын 05-ны дотор аймгийн Онцгой комисст танилцуулахыг “Эрсдэлийн үнэлгээ мэдээлэл, харилцааны баг” (Д.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн цэцэрлэг, сургуулийн анги, бүлгүүдийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс үе шаттайгаар танхимаар эхлүүлсүгэй.

5. Сургалтын үйл ажиллагааны явцад халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн бэлэн байдлыг хангуулан, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэгийг тухай бүрт үзүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьж, голомтот бүс нутгаас зорчин ирж буй багш, ажилтан, сурагчдыг PCR-ын шинжилгээний хариуг үндэслэж нэвтрүүлэх, шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн

шинжилгээнд хамруулах, гэрийн тусгаарлалтад 7 хоног хянаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд түр журмыг хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад бэлэн байдлын үнэлгээ хийн, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх үйл ажиллагаанд мэргэжил арга зүйгээр ханган, сургуулийн орчинд ковид-19 цар тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. МӨНХБААТАР